

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг

| | |
|--|------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2-3 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 4-14 |

-
- 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл** 4-14

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 04-ний өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Ш.Бямбасүрэн, Т.Доржханд, Г.Лувсанжамц, П.Наранбаяр, Ч.Номин, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Ж.Галбадрах, Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, А.Ганбаатар, Д.Ганбат, С.Лүндэг, Н.Номтойбаяр;

Тасалсан: Н.Алтаншагай, Х.Баттулга, Э.Батшугар, Б.Жавхлан, Ц.Мөнхбат, Э.Одбаяр, Ц.Туваан, Ж.Энхбаяр;

Хоцорсон: С.Амарсайхан-18 минут, Ж.Батжаргал-07 минут, Г.Ганбаатар-32 минут, П.Ганзориг-01 минут, Л.Гантөмөр-17 минут, Ц.Даваасүрэн-32 минут, Б.Жаргалан-33 минут, Б.Заяабал-32 минут, Ж.Золжаргал-02 минут, Т.Мөнхсайхан-07 минут, П.Мөнхтулга-02 минут, Ц.Мөнхтуяа-10 минут, Б.Түвшин-06 минут, А.Ундраа-13 минут, Н.Учрал-09 минут, Г.Уянгахишиг-07 минут, С.Эрдэнэболд-16 минут.

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг, Д.Үүрийнтуяа, С.Бямбацогт нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч, хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 12
Бүгд: 94
87.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулах нь зүйтэй гэсэн санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжив.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /11:37/

Уг асуудлыг 11 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 35 минут үргэлжилж, 126 гишүүнээс 96 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
11 цаг 03 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. 73 гишүүн бүртгэгдэж, ирц 57,9 хувьтай болсон байна. 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 1 асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу танилцуулна. Индэрт урьж байна.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.8-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн авсан бол хууль, тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгох тухай хууль, тогтоолыг хэлэлцэж, баталж болно гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолыг хүчингүй болгох тухай хууль, тогтоол, түүнчлэн “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Засгийн газраас Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын

2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн чуулганы чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан бөгөөд уг хуулиар Улсын Их Хурал Улсын төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол Засгийн газар холбогдох төсвийн төслийг дахин өргөн мэдүүлэхэд төсвийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэх цаглавар, төсвийн төсөлд хийх олон нийтийн хэлэлцүүлгийн зохицуулалт хамаарахгүй байхаар заасан.

Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаас Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуультай холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин өргөн мэдүүлсэн тохиолдолд Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх дэгийн талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу ахлан, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Бум-Очир, Ганмаа, Очирбат, Хэрлэн, Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэйгээр Байнгын хорооны 2024 оны 8 дугаар тогтоолоор байгуулж, саналаа нэн яаралтай боловсруулан Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасан.

Ажлын хэсэг хуралдаж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журмыг баримтлан санал, дүгнэлтээ гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг боловсруулан Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанд танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Очирбат нар улсын төсвийн төслийг дахин өргөн мэдүүлэх зохицуулалт бий болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэг тодорхой байх шаардлагатай тул 1 удаагийн дэгийн хуулийн төслийг боловсруулж шийдвэрлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир, Очирбат нар Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг хэлэлцэн шийдвэрлэхэд цаг хугацааны хувьд 1 удаагийн дэгээр хэлэлцэх шаардлагатай, мөн Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуугаар ажлын хэсгийг дахин ахлуулан ажиллуулах болон цаашид дэгийн хуульд байнгын зохицуулалт оруулах асуудлыг судлах ажлын хэсэг байгуулах талаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал хэлж, үг хэлсэн болно.

Ажлын хэсгээс боловсруулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Монгол Улсын Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэх талаар Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүнд баярлалаа. Өнөөдөр бол бас энэ төсөвт хориг тавигдаж, Төсвийн тухай хууль хүчингүй болсонтой холбогдуулж Засгийн газраас шинээр төсвийн төсөл өргөн барихаар болсон. Энэ өргөн баригдаж байгаа төсвийн төсөл маань өөрөө цаг хугацаандаа батлагдах чухал нөхцөлтэйгөөр үндсэндээ өргөн баригдана гэсэн үг. Яагаад гэхээр улсын төсөв батлагдсаны дараа аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд төсвийн жил эхлэхээс өмнө орон нутгийн төсвөө батлах үүрэгтэй.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд эдгээр асуудал дээр их тийм нухацтай хандаж, энэ дэгийн тухай хууль, өнөөдрийн ажлын хэсэг, Ёс зүй, дэгийн байнгын хорооноос оруулж ирж байгаа асуудал дээр анхааралтай хандаж, асуудалдаа нухацтай хандаарай гэдгийг бас зориуд хэлэхийг хүсэж байгаа юм.

Өмнө нь бас Ёс зүй, дэгийн байнгын хорооноос Ерөнхийлөгчийн хориг тавигдсантай холбоотой хориг тавьсан нөхцөлд бүхлээр нь тавигдсан нөхцөлд төсвийг хэрхэн хэлэлцэх вэ гэдэг асуудлаар хуралдаж, Хууль зүйн байнгын хороотой хамтарч хуралдаж ажлын хэсэг байгуулагдаад хэлэлцэх 1 удаагийн хуулийн төслийг оруулж ирсэн. Харамсалтай нь Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжээгүй учраас буцсан байгаа.

Өнөөдөр бас ахиж энэ дэгийн зохицуулалтыг оруулж ирж байгаа. Энэ орж ирснээрээ бид богино хугацаанд улсын төсвөө хэлэлцэх нөхцөлийг үүсгэх боломжтой гэж үзэж, оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Ингээд ажлын хэсгийн дарга Лодойсамбуу гишүүн, Байнгын хорооны дарга Баярбаатар нараас Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгөхийг хүсэж байна. 5 гишүүнээр тасаллаа.

Энэ урд талын эгнээнд сууж байгаа олон сонгогдсон гишүүд ингээд өнөөдөр ч гэсэн хоосон харагдаж байгаа биз. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд ирсэн ирцээрээ суудлаа эзэлдэг байх тэр зохицуулалтыг хийхээр журам боловсруулж эхэлсэн байгаа. Энэ ер нь бол Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлага, ёс зүйн талаар ард иргэд маш ихээр шаардаж байгаа. Нийтээр нь харлуулдаг байдал биш, идэвхтэй оролцдог, ажил хэрэгч байгаа хүмүүс нь Улсын Их Хурлынхаа үйл ажиллагаанд оролцох тэр оролцоогоор нь дэмжиж, урамшуулах энэ ажлыг бол зохион байгуулна гэсэн ийм байдалтайгаар журам боловсруулж эхэлж байгаа. Одоо олон нийтэд ч гэсэн бид ингээд хов хоосон парламентын танхим харагдаж болохгүй.

Яг өнөөдрийн байдлаар жишээ нь хурал эхлээд удаагүй байна. 82 гишүүн ирцэд бүртгэлтэй, танхимд 60 гаруй гишүүн л суугаад л үлдчихдэг. Өглөө орж ирээд л бүртгүүлчхээд л гараад явчих юм. Нэг сайхан эрт ирдэг, ирцтэй. Тэгээд

өдөржингөө хуралд суухгүй, бүх санал нь дандаа “эсрэг” гардаг гишүүд зөндөө байна. Тийм учраас энэ оролцоогоо хангаж байгаа гишүүдийг урагшаагаа суух тэр боломж нөхцөлөөр нь бол бүрэн хангах ёстой гэж ингэж үзэж байгаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн ирцийнхээ дарааллаар асуултаа асууна.

Б.Пүрэвдорж: Өнөөдөр ингээд бид нар бас энэ Засгийн газрын оруулж ирсэн бүтэлгүй төсвийг Ерөнхийлөгч хориг тавьсны дагуу тэрийг засах гээд, янзлах гээд яваад байгаа юм. Тэгээд яг ингээд ирцийг би хараад сууж байна. Засгийн газрын л бүтэлгүй юм шүү дээ. Тэгээд өнөөдөр ингээд харахаар 12, 13 сайд нь алга байна шүү дээ. 13. Үгүй ээ, би тэгээд таныг хэлчихье. Дэлгэрсайхан сайд байгаа юм байна. Хэлчихье таныг. Үгүй ээ, ингээд Батсуурь байгаа юм байна. Тэгээд бусад нь алга байна шүү дээ. Та 2, та 3 уу. Нэрийг чинь хэлэхгүй. Ингээд бусад нь алга байна шүү дээ. Ингээд ирцээ сайжруул. Засгийн газрын ажлыг хийх гэж бид нар ядаж байна. Хамаг цагаа алдаж байна. Өчнөөн олон том том төслүүдийг, тэрний хөтөлбөрүүдийг, гэрээнүүдийг оруулж байж ажлаа хиймээр байна. Тэгээд ингээд сайд нар нь өөрсдөө алга болчихдог. Тэгээд л нэг том юм ярьсан. Тэгээд л ерөөсөө энэ төрийн ажил явдаггүй. Хамтарсан гэгчхээд дандаа л энэ Ерөнхий сайд нь хамтраад энэ Их Хурал нь хамтраад яваад байх шиг байгаа юм. Гэтэл доогуураа албан тушаалтан нь бүгдээрээ дунд хуруугаа өгчхөөд, май та нартай хамтарна гэж байхгүй шүү гээд. Бүгдээрээ ийм байдалтай. Сайд нар нь тэр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь, тэр “Эрдэнэс MGL” нь бүгдээрээ л ийм байдалтай байна шүү дээ. Тэгээд өчигдөр тэр Мөнхсайхан надтай яаж харьцаж байна. Хар даа. Бүр одоо бүр идэж уугаад юм хум нь ингээд тулчихсан, бүр нэг баяжчихсан нөхдүүдийн араншин шал ондоо байх юм.

Д.Амарбаясгалан: Тийм төсөв өргөн баригдаад, шинээр өргөн барьсан төсөв дээр зайлшгүй гадаад томилолттой явж байгаа, олон улсын хурал, арга хэмжээнд эртнээс төлөвлөсөн оролцож явж байгаа Ерөнхий сайд болон холбогдох Засгийн газрын 3 гишүүн байгаа. Бусад Засгийн газрын гишүүд энэ төсөв хэлэлцэхэд бүрэн оролцох ёстой. Өнөөдөр Дэлгэрсайхан гишүүний гадагшаа явах томилолтын хүсэлт ирсэн. Тэрийг цуцалсан байгаа. Одоо төсөв хэлэлцэх цаг үе дээр сайд нар ялангуяа оролцоогоо бүрэн хангах ёстой шүү. Бид нээрээ одоо хэчнээн ч удаа төсөв хэлэлцэж байна. Хэн хэнээс нь үүдэлтэй алдаа дутагдлууд дахин дахин давтан гарсаар л байгаа. Тэгэхээр энэ дээр бол онцгой анхаарч оролцоно шүү. Бас энэ Улсын Их Хурлын гишүүдийн хэлээд байгаа саналуудыг бас та хэд маань хүндэтгэж авч үзэж байгаарай. Төсөв дээр Засгийн газрын гишүүд бүрэн байж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд салбарынхаа төсөвт оруулсан бодлогоо тайлбарлах хамгаалах үүрэгтэй. Энэ дээрээ онцгой анхаарна шүү. Мэдээж Ерөнхий сайд бол эртнээс төлөвлөсөн байсан Копын хуралд оролцож байгаа. 2027 онд Монгол Улсад энэ Копын арга хэмжээ зохион байгуулагдана. 2 жил тутам зохион байгуулагдаж байгаа. Энэ жил Саудын Арабд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд зайлшгүй оролцох шаардлагатай учраас Ерөнхий сайд салбарын чиглэл хариуцсан 3 сайдын хамтаар бол оролцоод явж байгаа. Мэдээж энэ 7 хоногтоо багтаж ирэхээр байгаа. Тэгэхээр энэ дээр бол онцгой анхаарна шүү гэдгийг бас хэлье. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг

хэлэлцэх дэгийн тухай гэдэг энэ асуудал байна. Төсөв маань өргөн баригдаагүй байгаа. Төсөв өргөн баригдаагүй байгаа цаг хугацаанд төсвийн төслийг хэлэлцэх дэгийн тухай асуудлыг хэлэлцэж болох уу гэдгийг 1 дүгээрт асуух гэсэн юм.

2 дугаарт өчигдөр бас Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 2016 оны 2 сарын 18-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар хуулийг батлагдсан өдрөөс дагаж мөрдөхөөр заасан нь Үндсэн хуулийн зөрчил гэж 2016 онд дүгнэсэн байгаа юм. Бид нар сүүлийн үед энэ гарч байгаа хуулиуд маань батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө гээд ингээд байнга ийм үг үсэгтэй явж байна. Тэгээд сүүлд нь энэ Үндсэн хуулийн цэц дээр очоод, магадгүй эсвэл энэ төсвийн тухай хууль чинь бид нарын баталсан бүх хууль хүчингүй болчих вий дээ. Дахиад нэг асуудал үүсэх вий дээ ...

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүнд 1 зүйлийг логиктой ойлгохыг хүсье. Төсөв хэлэлцэх дэгээ батлаагүй байж байж төсөв хэлэлцэж эхэлнэ гэж юу байх вэ гэдгээ өөрөө бод. Төсөв хэлэлцэж эхэлчхээд дэгээ өөрчлөх гээд сууж байдаг тийм парламент байх уу. Бас тэрийгээ бод. Одоо хэдүүлээ аливаа асуудалд нухацтай хандъя гэж хэлээд байна шүү дээ. Бүгд л гадна талдаа янз янзаар харагдаж байгаа гэдгийгээ их сайн ойлгоно шүү. Лодойсамбуу гишүүн хариулъя.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүний асуултад ерөнхийдөө Их Хурлын дарга өөрөө хариулчихлаа даа. Одоо төсөвт хориг тавьсан, дараа нь төсвийг хориг тавьсныг хүлээж аваад 2 зам бид нарт байсан. Нэг нь бол хориг тавьсан хуульдаа нэмэлт, өөрчлөлтийг оруулаад явах, нөгөөдөх нь хүчингүй болгох байсан. Хүчингүй болгох замыг нь сонгоод ингэснээрээ дахин өргөн барихаар болсон. Шинээр төсвөө өргөн барихаар. Ингээд өргөн барья гэхээр бид нарт ямар дэгээр хэлэлцэх вэ гэдэг нь л тодорхойгүй байгаад байгаа хэрэг. Тэгэхээр одоо эхлээд ямар дэгээр хэлэлцэх вэ гэдэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Дэгийн тухай хууль дээр төсвийг хэрхэн хэлэлцэх вэ гэдэг тэр зүйл, заалтуудыг ашиглахын тулд л гарцыг нь энэ дэгийн хуулиар нээж өгч байгаа. Тэгээд энийг нээсний дараа бид нар төсвөө хэлэлцэх боломжтой болно гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. 1 асуулт, 1 санал байна. Би эхлээд саналаа бас хэлье гэж бодож байгаа юм. Ер нь зүгээр энэ дэгийн хуулиа бас ажлын хэсэг гаргаад, гишүүдээрээ, холбогдох Байнгын хороодоороо магадгүй яг энэ зарим хоригийн асуудлыг, цэцийн тодорхой дүгнэлттэй холбоотой асуудлыг ч юм уу, холбогдох Хууль зүйн байнгын хороонд ч гэдэг юм уу гээд яг мэргэжлийн Байнгын хороонд бас оролцох, эргээд нэг жоохон цаг хугацаатай бас энэ асуудлуудаа нэг сайжруулах боломжийг эртнээс Улсын Их Хурлын дарга бас анхаарч ер нь ажлын хэсгээ гаргачихвал яадаг юм бэ. Он гаргаад ярья гээд байдаг. Яг үнэндээ хэлэхэд бид нар алхам тутам ийм ойлгомжгүй бас ерөнхий байдлаар зохицуулаад орхичихсон хэрвээ ийм тохиолдол гарвал яах вэ гэдэг дээр бас дутуу бодчихсон ийм дэг бол байсан байна. Бид хэд одоо харж байна шүү дээ. Энэ парламент батлаагүй гэдэг зүйлийг би бас энд тодорхой хэлчихье. Энэ өнөөдөр үүсээд байгаа нөхцөл байдлууд ч өмнө нь үүсэж байгаагүй. Тэгэхээр бид хэдэд бас шинэ сорилтууд гарч байгаа нь үнэн. Үүнтэйгээ зэрэгцүүлээд ер нь энэ дэгийн хуулийг ойлгомжтой болгохгүй бол асуудал гарч ирэхээр тааруулж бас дэг хийгээд байхаар бас их хардалтууд, янз бүрийн байдлаар бас үл ойлголцлууд гарах юм.

Тэгэхээр энийгээ бид нар бас эртнээс тооцоолж бас зарим зүйлүүдийг бодъё. Тэгээд жишээ нь хориг дээр л гэхэд төсвийн хууль гэдэг бол онцгой хууль учраас бусад ердийн хууль дээр тавьсан хоригийг хэлэлцэж байгаа юм шиг хүлээж авч болохгүй. Тэр дундаа төсвийн хууль дээр бүр бүхэлд нь хориг тавьчихвал яах вэ гэдэг асуудал ч хүртэл ингээд яригдаж байна. Тэгэхээр ер нь зүгээр хоригийн бас хязгаарлалт гэж байх уу, үгүй юу бас бодмоор байгаа юм. Үнэхээр парламентын засаглалтай оронд бол жишээ нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах эсэх асуудал, магадгүй улс төрийн томилгооны асуудал дээр хориг тавьдаггүй ч гэдэг юм уу ийм жишгүүдийг гаргачихсан шүү дээ.

Тэгэхээр энэ нөгөө парламент өөрөө төгөлдөрших энэ зүйл рүүгээ явдаг зүйлүүдийг эртнээс засаад, уялдуулаад явмаар байна. Тэгэхгүй бол ингээд институц хоорондын үл ойлголцол гарах гээд байгаа ч юм шиг. Тэгээд байгаа тэр хүрээндээ л асуудлаа ярьж байгаа учраас анхнаас нь энэ хуулийг хүрээ хязгаар, зохицуулалтыг нь тодорхой болгож өгөөгүй учраас асуудал үүссэний дараа тал тал руугаа л бие биеэ буруутгасан өнгө аясаар явж байна. Энэ дээрээ хэдүүлээ анхаараад бас Дэгийн хуулийг сайжруулах ажлын хэсгийг нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй гаргаач. Тэгээд хаврын чуулгандаа яадаг юм уу, ямар ч байсан жоохон тийм тулгуу биш нэлээн ажиллая гэж бодож байна. 1 дүгээрт энэ саналыг хэлэх гэсэн юм.

2 дугаарт яах вэ, зүгээр энэ орж ирсэн хууль бол байна. Энэ хоорондын хэлэлцүүлгийг 5 хоногийн зайтай хийх асуудлыг бас баримтлахгүй гэдгээс гадна ер нь 3, 4 дүгээр хэлэлцүүлгүүдийг шаардлагатай гэдэг юм уу эсвэл 2 дугаар хэлэлцүүлэг дээр асуудлууд цэгцэрсэн тохиолдолд уг нь хамтатгаад хийнэ гэдэг юм уу. Бид хэдэд 1 өдөр нэгдэхгүй байгаа юм. Яг энэ дээр бол аймаг, нийслэлийнхэн бол ямар ч байсан төсвөө батлах боломж бол байна. Ер нь дүүргүүд, сумууд бол хэцүү шүү. Бас яг үнэндээ хэлэхэд 1 хоног ч нэгдэхгүй. Тэгэхээр бид хэд бас Засаг дарга бас хориг тавьдаг энэ эрхийг нь бас хүндэтгэх ёстой. Яг үнэндээ хэлэхэд амжих ёстой л гээд байгаа болохоос биш тэр доор бас орон нутгийн түвшинд ойлголцол, янз бүрийн юм яаж явахыг мэдэхгүй шүү дээ. Тийм учраас 1 хоног нэгдэхгүй байгаа юм. Тэгээд энэ дээр ер нь 3, 4 дэх хэлэлцүүлгийг хамтатгаж хийж болно гэж ер нь ярьж болоогүй юм уу. Энэ хугацаа хэмнэх талаасаа ерөөсөө жоохон бодмоор байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бас л жоохон тийм дутуу юм ажиглагдаад байна.

2 дугаар хэлэлцүүлэг дээр гараад ажлын хэсэг нь үнэхээр сайн ажиллаад Улсын Их Хурал боллоо гэж үзсэн бол заавал ингэж хугацаа алдах биш. Уг нь бол ингээд л хамтатгаад л 1 цохиод л яаралтай л юмнуудаа уг нь хийчихмээр байгаа юм. Тэгээд ийм үе дээр бас Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа энэ тэр дээр бас уян хатан хандах ч юм уу тэр өдөртөө хоригийг тавих эсэхээ өгнө ч гэдэг юм уу ийм байдлаар ч гэдэг юм уу бусад зарим зүйлүүдийг уг нь нэг жоохон харчихмаар л байсан юм. Тэгээд 1 ийм ерөнхий ингээд нэг л аргацаасан .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дэг бол учир дутагдалтай байна. 76 гишүүнтэй байсан парламент маань асуудалд бас нэлээн ерөнхийдүү хандсан байж болзошгүй. Энэ дэгийн хуулийн өнөөдрийн байгаа дүр төрх бол бас байна. Гэхдээ бид өнөөдөр яаран энийгээ шууд өөрчлөх гээд дайрах нь бас учир дутагдалтай. Тодорхой цаг хугацаа энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой давуу болон сул талуудыг маш олон талаар харж туршиж байж энийгээ засаж залруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол бид бас бушуу туулай борвиндоо баастай гэхчлэн өнөөдөр тулгамдаж байгаа өнцгөөсөө

өөрчлөлтүүдийг хийгээд, маргааш ирэх бэрхшээлийг бас бүрэн харж чадаагүйгээр асуудлыг шийдэж чадахгүй гэсэн нэг ойлголт байна.

2-т нь Сайнзориг гишүүн маань хуульч гишүүн. Бас харамсалтай байна. Та Дэгийн тухай хуулиа унших хэрэгтэй. Дэгийн тухай хуулиар 72.4 дээр төсвийн төслийн 3, 4 дэх хэлэлцүүлгийг хамтран явуулж болно гэсэн заалт байж байгаа юм. Байж байгаа юм. Энэ өөрөө хэрэгжиж байгаа хууль байхгүй юу. Тэгэхээр одоо бас энэ ажлын хэсгийн нөхдүүд, энэ Ёс зүй, дэгийн байнгын хорооны түвшинд ярьсан зүйлүүдийг бид буруутгах, муутгах өнцгөөс нь харахаасаа илүүтэйгээр алдаа дутагдалгүй байх өнцгийг нь илүү харж ажиллавал, ажил хэрэгч байвал их сайн байна гэж байгаа юм. Тийм ээ. Тэгэхгүй бол гишүүд маань өөрсдөө нөгөө хуулиа бүрэн уншаагүй байж байж асуудалд шүүмжлэлийн өнцгөөс нь хандаад ажил хэрэгч олон асуудлууд парламентын танхимд унадаг байдал бол хэвийн үзэгдэл болж болохгүй. Энэ дээр бас онцгой анхаарах ёстой шүү гэдгийг хэлье.

Жамбын Батсуурь сайд асуулт асууя. Давхардсан байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе. 1 тодруулах зүйл байна. Бид нар Дэгийн хуулийнхаа 30.2-т заасан хугацааг яаж зохицуулах бол? Ер нь бол яах вэ 69.1-ээрээ бол үндсэндээ өргөн барих хугацааг, хэлэлцэх хугацааг, эхэлж хэлэлцэх хугацааг, дуусах хугацааг заасан байна. Энийг бол мөрдөхгүй гээд явчхаж байгаа юм байна гэж ойлгож байна. Сая Их Хурлын дарга хэлсэн. 3 дахь, 4 дэх хэлэлцүүлгийг хамтад нь зохион байгуулж болно. 1, 2, 3 дахийн хоорондох хугацааг 5 хоног гэдгээ яаж зохицуулах юм бол. Засгийн газар хэрвээ яаралтай горимоор өргөн барих юм бол мөрдөхгүй байж болох заалт байгаа. Тэгэхээр яаралтай горимоор өргөн барина гэж тооцоод орхих юм уу, эсвэл эндээ зохицуулалт оруулах ёстой юу. Энийг яаж ажлын хэсэг ярилцсан бол.

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуултад хариулъя.

Ч.Лодойсамбуу: Тийм. Энэ бол 69.1 гээд бид нарт нөгөө хуулиар олгогдсон хугацаагаа л бид нар мөрдөх боломжгүй болчхож байгаа учраас энэ хэсгийгээ тойрох нэг замыг л гаргаж ирж байгаа. Өчигдөр Их Хурлаар баталсан Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх л гарцыг нь нээж байгаа хэрэг. Ингээд явчихаар яаралтайгаар орохоор хэлэлцүүлэг хоорондын зай, хоног хугацаа, цаглавар нь ямар байх вэ л гэж ерөнхийдөө асуугаад байх шиг байна. Тэгэхээр энд бол даргын дэргэдэх зөвлөлийн хурал бол энэ цаглаварыг гаргаад явах хуулиараа ийм бүрэн боломжтой байж байгаа. Тэгээд энэ дэгийн хуулиараа түрүүн Их Хурлын дарга хэлсэн. 72.4 дээр төсвийн төслийн 3, 4 дэх хэлэлцүүлгийг хамтад нь явуулж болно гээд ингээд бүх гарцууд нь байж байгаа учраас энэ бол боломжтой гэж бодож байна. Баярбаатар дарга нэмж хариулах уу.

Д.Амарбаясгалан: Манай Лодойсамбуу гишүүн чинь ажлын хэсгийн дарга шүү. Хурлын даргын ажил хийгээд унах юм. Баасандорж дарга нэмж хариулъя.

Б.Баасандорж: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Баасандорж. Манай дэгийн тухай хуулийн 30 дугаар зүйл дээр хуулийн төслийг хэлэлцэн батлах үе шат байгаа. Энэ 30.2 дээр хуульд батлах хугацааг тусгайлан зааснаас бусад хуулийн төслийг хэлэлцүүлэг хоорондын зай 5 хоног байна шүү гэж хэлсэн байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл манай Монгол Улсын

2025 оны төсвийн тухай хууль 11 сарын 15-нд батлагдах ёстой байсан. Ерөнхийлөгч хориг тавиад, бүхэлд нь хоригийг хүлээж аваад, хууль маань хүчингүй болсон. Их Хурлаас 12 сарын 10-нд өргөн мэдүүлнэ шүү гэдэг үүргийг тогтоолоор өгсөн байгаа. Тэгэхээр оноос өмнө сая өчигдөр батлагдсан Төсвийн хууль дээр энэ ондоо багтаж батлах ёстой байгаа. Тэгэхээр хуульд тусгайлан хугацааг нь заачихсан байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн барина. Их Хурал нэн яаралтай горимоор хэлэлцэх үү, үгүй юу гэдгийг Их Хурлын гишүүдийнхээ олонхоор шийдээд, энэ 30.2-оор явах юм. Энэ бол Дэгийн хуулийнхаа.

Д.Амарбаясгалан: Өнөөдрийн дэгийн тухай хуульд 1 удаа хэлэлцүүлээд батлах гэж байгаа энэ хууль бол төсвийн хэлэлцүүлэг хоорондын хугацааг хэмнэх л зорилготой. Үндсэн зорилго нь. Тэгээд өдөр тутамд парламент хуралдаад энэ хэлэлцүүлгээ хийчих боломжтой. Хэрвээ энэ хууль дэмжигдчихвэл Засгийн газар өнөөдөр хуралдаад магадгүй төсвийнхөө төслийг өргөн барьчихвал бид энэ 7 хоногтоо 1 дүгээр хэлэлцүүлгээ хийгээд, энэ амралтын өдрүүдээр ажлын хэсгийг хуралдуулаад, ирэх 7 хоногийн ажлын 5 өдөр 5-ууланд нь Байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулган тасралтгүй хуралдаад энэ асуудлаа шийдвэрлэе гэж байгаа юм. Нэг л зүйл байгаа шүү дээ. Одоо бид бол энэ дээр хариуцлагатай. Энэ Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд байгаа энэ төсвийн хэлэлцүүлгийн асуудал орон нутгийн түвшинд очиж хүндрэл үүсгэж болохгүй гэдэг байр суурийг хангах гэж бас хурдтай, нэн яаралтай горимоор хэлэлцэх зүйлийг оруулж ирж байгаа гэж ингэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Дэгийн хуулийг бас энэ удаа бол 1 удаагийн өөрчлөлт орох гэж байх шиг байна. Цаашдаа бид нар бас шинэ парламент 126 гишүүнтэй, шинэ тогтолцоогоор бас хуралдаад явж байгаа. Үүнтэй холбоотойгоор бас нэлээн өөрчлөх олон асуудал гарч ирж байх шиг байна. Сая бас Их Хурлын дарга бас ярилаа. Энэ ирсэн ирцээрээ урагшаагаа суудаг больё гэж. Би бол дэмжиж байгаа. Яах гэж Их Хурлын гишүүн болдог билээ. Бүгдээрээ л Их Хурлын гишүүн болох гээд л төр, түмнээ төлөөлнө гээд маш их зүйлийг амладаг. Маш их хөрөнгө мөнгө зарцуулдаг. Худлаа, үнэн ярьдаг. Уулыг нураана, усыг эргүүлнэ гэдэг. Тэгээд Их Хурлын гишүүн болчихоод ажилдаа ирдэггүй, хуралдаа суудаггүй, ард түмнээ төлөөлдөггүй, ард түмнийхээ эрх ашгийн төлөө ажилладаггүй, хувийнхаа эрх ашгийн төлөө ажилладаг ийм зүйл зөндөө л байдаг. Энэ парламент ч биш урд талын парламент зөндөө л байсан. Энийг бид нар цэгцлэх ёстой. Яах гэж Их Хурлын гишүүн болдог билээ тэрийгээ бодох ёстой. Бодох ёстой. Ер нь бол тэгээд хуралдаа ирдэггүй, хувийнхаа ажил амжуулаад, худлаа үнэн яриад яваад байдаг хүмүүс чинь олон сонгогддоггүй шүү дээ. Тэгээд л 1 удаа сонгогдоод л алга болчихдог юм. Тийм болохоор бас тэр олон сонгогдоод байгаа хүмүүсийг бас ад үзээд байх шаардлага байхгүй байгаа юм. Ад үзээд байх.

Би 2016 онд бас энэ хуралдаа ирдэггүй нөхдүүдийг цэгцлэх гэж урьд нь яадаг байсан карт шургуулаад ирцдээ орчихдог. Тэгээд өмнөөс нь кнопын дараад л санал өгчихдөг байсан. Энийг өөрчилж 2016 онд хурууны хээгээр ирцээ бүрдүүлж, хурууны хээгээр саналаа өгдөг, зөвхөн өөрөө саналаа өгдөг энэ хуулийг санаачилж батлуулсан. Үүнээс хойш харьцангуй тэр төгөлдөр хуур тоглодог, саналаа өгөх гэж өмнөөс нь санал өгдөг, өмнөөс нь ирцийг нь бүрдүүлээд, гэртээ унтаад хувийнхаа ажил амжуулаад явж байдаг зарим нөхөд нь ирээд сууж байгаад цөөхөн нөхөд нь ад болдог энэ асуудлыг цэгцэлсэн. Үүнтэй адилхан бид нар энэ парламентын бас

нэг дэвшил бол ирсэн ирцээрээ үгээ хэлж байгаа. Асуултаа асууж байгаа. Яг үүнтэй адилхан ирсэн ирцээрээ урагшаагаа суудаг болчих. Энэ бас зөв. Урд суух, хойно суухад ялгаа байхгүй. Ямар ч ялгаа байхгүй. Тийм болохоор ийм байдлаар бас асуудлаа шийдээд явах нь зөв байх. Ер нь яах гэж Их Хурлын гишүүн бол болдог билээ гэдгээ бас бодох ёстой. Төрд ард түмэн итгэдэг. Төрийн нэр хүнд бас унаж байгаа. Энэ Улсын Их Хурал дээр, Засгийн газар дээр хийж байгаа ажлаа сайн хийх юм бол ард түмний итгэх итгэл улам сэргэнэ, төр түмнийхээ төлөө төрийн минь сүлд өршөө гээд төрөө хүндэлдэг болно.

Бид хариуцлагагүй болохоор, бид ажлаа хийхгүй болохоор биднийг илүү үзэж байгаа, нүд үзүүрлэж байгаа. Тийм болохоор Их Хурлын гишүүд ч тэр, Засгийн газрын гишүүд ч тэр аль аль нь хариуцлагатай байх ёстой. Одоо бид нар төсвөө ингээд баталж чадахгүй асуудал болоод сууж байгаа чинь хариуцлагагүй байдал. Үүнээс болоод ард түмэн чинь бухимдаж байна. Тийм болохоор энэ дээр бас цаашдаа бас анхаарах ёстой. Их Хурлын дэгийн хуульдаа бас энэ өөрчлөлтийг оруулчихъя бүгдээрээ. Хариуцлагатай байцгаая. Тэр цоллодог байя бүгдийг нь. Хуралдаа ирэхгүй байгаа, тасалдаг нөхдүүдийг.

Ажлын хэсгээс асуух гэж байгаа асуулт бол хууль ингээд бид 1 удаагийн хууль батлах гэж байгаа. Энэ хуулиараа дахиад Ерөнхийлөгч хориг тавивал яах вэ. Бүхэлд нь хориг тавьчихвал бид яах вэ. Ямар зохицуулалт байна. Энийг бас давхар харж ярьсан уу, ярилцаагүй юу. Хэсэгчлээд хориг тавивал бас яах вэ. Энэ дээр та бүхэн бас ярьсан уу, яриагүй юу. Яагаад гэвэл хуулийн процесс чинь хэлэлцэх эсэх, хэлэлцүүлгүүд, эцэслэн батлаад, эцэст нь дахиад хоригийн хугацаа, дараа нь Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдэж байж, хууль хүчин төгөлдөр болдог. Тэгэхээр 1 удаагийн хууль ч гэсэн хүчин төгөлдөр болох процесс дунд энэ бас давхар бодсон тооцсон байх ёстой. Энэ дээр та бүхэн бас ярилцсан зүйл байгаа юу.

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуултад хариулъя.

Ч.Лодойсамбуу: Тийм. Энэ тухай бид нар ярилцсан. Нэг зүйлийг бас ойлгуулаад хэлмээр байгаа юм. Одоо байгаа Дэгийн хууль дээрээ нэмэх нь дахиад нэг дэг хийгээд шинээр нэг ийм дэгийн хууль гаргаж ирээд байгаа юм шиг тийм ойлголт үүсээд байгаа юм. Одоо бид нарын энэ хэрэглээд байгаа, өргөн бариад байгаа хуулиуд ч гэсэн үндсэндээ бид нарын мөрдөж байгаа Дэгийн хууль бол хэрэгжээд байгаа. Манай мөрдөж байгаа Дэгийн хуулийн 16.1 дээр тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж, саналаа нэгдсэн хуралдаанд оруулна гэгчхэж байгаа. Тэгээд дээр нь Үндсэн хуулийн 25.4 дээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа хийнэ гэсэн журмаа зөвхөн хуулиар тогтооно гэгчихсэн байгаа. Энэ хуулиуд л үндсэндээ хэрэгжээд явж байн гэж ойлгож болно. Дахиад хэрвээ хориг тавьсан тохиолдолд бүхэлд нь юм уу, хэсэгчлэн байдлаар хориг тавьсан тохиолдолд яг энэ арга замаараа л явна. Ер нь цаашдаа бид нар бол Дэгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулна гэдгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо дээр байнга ярьж байгаа. Юу юугүй бас яарах нь учир дутагдалтай байна гэж. Яагаад гэхээр бид нар ингээд хэдэн удаагийн нэгдсэн чуулганы хуралдаан явуулж үзээд одоо бид нар ингээд асуудал байгаагаа мэдээд, өнөөдрийг хүртэл ингээд шинэ зүйлүүдийг олж хараад байна шүү дээ. Тэгэхээр ингээд ямар ч байсан намрын чуулганаа явж үзээд, үүний ар дээр яг нэгдсэн дүгнэлт хийгээд, Дэгийн хууль дээрээ нэг мөсөн өөрчлөлтүүд хийгээд явъя гэж.

2 дугаарт бид нарт бас онолын үүднээс яригдах юмнууд байгаад байгаа. Ер нь эрх мэдэл хуваарилах онол талдаа ч гэсэн бас хэдийгээр хуулиараа боломжтой байгаа ч гэсэн яг Ерөнхийлөгч бол хориг тавих хуулиараа эрхтэй. Гэхдээ нөгөө талдаа бас Их Хурлынхаа үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох, хууль батлах процессыг нь ингээд зогсоочих ийм бас онолын үүднээс ийм гажиг бас харагдаад байгаа юм. Тэгээд энийг бид нар ажлын хэсэг дээр ярьсан. Бас нэг зүйлийг тодруулаад бас хэлмээр санагдаад байна. Энэ Их Хурал ерөөсөө л ингээд чадамжгүй, энэ Их Хурал ерөөсөө шинээр бүрдсэн парламент нэг л болохгүй байна гэдэг ийм юмыг гишүүд маань ч гэсэн их ярьж байгаа. Ер нь сүүлийн үед хүмүүс тэгж дүгнэж байна гэж бид нар өөрсдөө бас нэг ийм хэтийдүүлсэн дүгнэлт хийгээд байгаа юм. Яг үнэндээ нөгөө талаасаа харах юм бол өмнөхүүд шиг бас багцлагдахгүй, хайрцаглагдахгүй, энэ 126 гэдэг тоо чинь дээр нь шинээр орж ирсэн энэ 80 гаруй гишүүд чинь бас нэг чамбайрах юм байна гэдэг ийм сайн дүгнэлт бас харагдаж байна шүү дээ. Бас юм ингээд өмнөх шигээ бүлэглээд, багцлагдаад, хайрцаглагдаад ингээд явдаг байсан. Хүч түрээд явдаг байсан энэ зүйл ер нь цаашдаа байхгүй юм байна. Намын бүлгүүд дээр ч байхгүй юм байна гэдэг нь 2 намын бүлгүүдийн гишүүдийн илэрхийлж байгаа байр сууринаас харагдаж байна. Тэгэхээр энэ парламент бол миний бодож байгаагаар бол ер нь ирэх жилүүдэд бас олон зүйлийг яг энэ төсөв дээр хандаж байгаа шигээ бусад хуулиуд дээр хандаж байгаа шигээ ер нь олон зүйлийг тунгалагшуулах, олон зүйлийг ер нь сайн зүг рүү нь чиглүүлэх ийм сайн парламент болох юм байна гэж би бол дүгнэж байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулахаар байна. Эцэслэн батлах чинь нийт гишүүдийн олонхоор Төсвийн байнгын хороо давхар хуралдаж байна. Одоо орж ирж байна уу. Тэгвэл эхлээд ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Танхимд 68 орчим гишүүн байх шиг байх юм. Ирц бүртгэлийн санал хураалтыг явуулаадахъя. Санал хураалт. 69 гишүүн санал хураалтад оролцсон байна. Төсвийн байнгын хорооны гишүүд бас танхимд орж ирсэн байна. Санал хураалтын томъёоллыг нь уншъя. Одоо хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг Ёс зүй, дэгийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа. Ингээд санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад 94 гишүүн оролцож, 82 гишүүн дэмжиж, 87,2 хувиар дэмжигдлээ. Хуулийн төсөл батлагдлаа.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярбаатар гишүүн горимын санал.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Хууль батлагдлаа. Баярлалаа. Одоо эцсийн найруулгаа сонсьё гэдэг горимын саналыг гаргачихъя.

Д.Амарбаясгалан: Санал хэлж байгаа юм байна. Одоо тэгвэл Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргын гаргасан саналыг гишүүд дэмжиж байна уу. Дэмжиж байна. Тэгвэл Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан саналын дагуу батлагдсан хуулийн эцсийн найруулгыг сонсьё.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Хэвлэн тараагдсан байгаа. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Төсвийн байнгын хороо үргэлжилж хуралдах юм байна.

11.38 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ